



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/135

Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 2 иргэнд эзэмшүүлсүгэй.


2. Иргэдийн эзэмшил газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэдэд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 156 дугаар, 2003 оны 211 дүгээр захирамжийн 14, 15 дахь хэсгийг, 1996 оны а/41 дүгээр захирамжуудыг хүчингүй болгосугай.


ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010376

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын  
18 -ний өдрийн А/18 дугаар захирамжийн хавсралт



**ХЭРЛЭН СУМАНД ГАЗАР ЭЗЭМШИЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ**

2021.03.09

Чингис хот

Д/д	Иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	"Цэнэ трейд" ХХК	2645009	937м <sup>2</sup>	3-р баг Баатрууд гудамж С-32 тоот	үйлчилгээний	38
2	"Цэнэ трейд" ХХК	2645009	753м <sup>2</sup>	3-р баг Баатрууд гудамж С-34	үйлчилгээний	38
3	Ш.Ганбат	СЮ60122774	2977м <sup>2</sup>	2-р баг Баатруудын гудамж М-32 тоот	үйлчилгээний	45
5	Г.Анхзаяа	СЮ83061203	1222м <sup>2</sup>	3-р баг Баатрууд гудамж	Үйлчилгээний	43